



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ
МОНГОЛ УЛС
БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар (цаашид "Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх) хоорондын нийгмийн хамгааллын салбар дахь харилцааг зохицуулах зорилгоор дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

**I БҮЛЭГ
ЕРӨНХИЙ ЗААЛТ**

**1 дүгээр зүйл
Нэр томъёоны тодорхойлолт**

(1) Энэхүү хэлэлцээрт хэрэглэгдэж байгаа нэр томъёог дараахь байдлаар ойлгоно:

(a) Нутаг дэвсгэр:

Монгол Улсын хувьд: Монгол Улсын нутаг дэвсгэр,
Бүгд Найрамдах Турк Улсын хувьд: Бүгд Найрамдах Турк Улсын нутаг дэвсгэр,

(b) Иргэн:

Монгол Улсын хувьд: Холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын иргэн гэж тодорхойлсон хүн,
Турк Улсын хувьд: Туркийн иргэншилтэй хүн,

(c) Хууль тогтоомж:

Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийгмийн хамгааллын тогтолцоотой холбогдсон хууль тогтоомж, бусад эрх зүйн болон захиргааны акт,

(d) Эрх бүхий этгээд :

Монгол Улсын хувьд: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,
Бүгд Найрамдах Турк Улсын хувьд: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,

(e) Эрх бүхий байгууллага:

Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэтгэвэр, тэтгэмж олгох үүрэг бүхий байгууллага,

(f) Даатгуулагч:

Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн дагуу даатгуулсан болон даатгуулж байсан Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын иргэн,

(g) Даатгалын хугацаа:

Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсхүл төлсөнд тооцогдох хугацаа,

(h) Тэтгэвэр:

Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан бүх тэтгэвэр, тэтгэмж болон бусад мөнгөн олговор,

(i) Оршин суух газар:

Байнгын оршин суух газар,

(j) Түр байх газар:

Түр оршин суух газар,

(k) Тэжээгчээ алдагч:

Тэтгэвэр олгох Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжоор эрх бүхий гэж хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын иргэн,

(2) Энэхүү хэлэлцээрт тодорхойлоогүй аливаа нэр томъёог тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

**2 дугаар зүйл
Хамрах хүрээ**

(1) Энэхүү хэлэлцээрийн үйлчлэлд нийгмийн даатгалын дараахь төрлүүдийг зохицуулсан хууль тогтоомж хамаарна:

A. Монгол Улсын хувьд:

а) Албан журмын даатгуулагчийн хувьд: өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн;

б) Сайн дурын даатгуулагчийн хувьд: өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, даатгал, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн.

В. Бүгд Найрамдах Турк Улсын хувьд;

- a) нэг болон түүнээс дээш тооны ажил олгогчтой гэрээ байгуулан ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүний тухайд тахир дутуугийн, өндөр насны, тэжээгчээ алдсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, жирэмсний болон амаржсаны даатгал,
 - b) хөдөлмөрийн гэрээгүй, өөртөө ажиллаж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тухайд тахир дутуугийн, өндөр насны болон тэжээгчээ алдсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, жирэмсний болон амаржсаны даатгал,
 - c) төрийн албан хаагчийн тухайд тахир дутуугийн, өндөр насны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн даатгал,
- (2) Энэхүү хэлэлцээр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилэн найруулж байгаа эсхүл орлож байгаа аливаа хууль тогтоомжид мөн адил хамаарна.
- (3) Нийгмийн хамгааллын шинэ хөтөлбөр, эсхүл нийгмийн даатгалын шинэ үйлчилгээ бий болгосон хуулийг энэхүү хэлэлцээрийн үйлчлэлд хамруулахдаа Хэлэлцэн тохиролцогч талууд нэмэлт хэлэлцээр байгуулах замаар асуудлыг зохицуулна.

3 дугаар зүйл Хамаарах хүн

Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эсхүл хоёр талын хууль тогтоомжид хамрагдаж байсан эсхүл хамрагдаж байгаа иргэн, түүний тэжээгчээ алдагчдад мөн адил үйлчилнэ.

4 дүгээр зүйл Эрх тэгш хандах

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа болон энэхүү хэлэлцээрийн зохицуулалтад хамаарах хүмүүс тухайн оршин сууж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын иргэний нэгэн адил тухайн улсын хууль тогтоомжоор олгосон эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

5 дугаар зүйл
Тэтгэвэр шилжүүлэх

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан эрх бүхий хүн нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт эсхүл гуравдагч оронд оршин сууж байгаа эсэхийг үл харгалзан тэтгэвэр олгох үүрэг бүхий Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу тогтоосон тэтгэврийг тухайн Хэлэлцэн тохиролцогч тал олгоно.

6 дугаар зүйл
Тэтгэврийг бууруулах, түдгэлзүүлэх ба цуцлах

Тэтгэврийг бууруулах, түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг Хэлэлцэн тохиролцогч талууд тус тусын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ
ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ

7 дугаар зүйл
Ерөнхий зүйл

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол;

- (1) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талд хөдөлмөр эрхэлж байгаа хүн тухайн хөдөлмөр эрхэлж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг даган мөрдөнө.
- (2) Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байрлах төлөөлөгчийн газарт хөдөлмөр эрхэлж байгаа хүнд тухайн төлөөлөгчийн газар байршиж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомж үйлчилнэ.
- (3) Нэгэн зэрэг Хэлэлцэн тохиролцогч хоёр талд хөдөлмөр эрхэлдэг хүн оршин сууж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- (4) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талд хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүн нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд оршин сууж байгаа тохиолдолд хөдөлмөр эрхэлж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- (5) Хэлэлцэн тохиролцогч хоёр талд хувиараа хөдөлмөр эрхлэгч оршин сууж байгаа талынхаа хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

(6) Хэлэлцэн тохиролцогч нэг талд хөдөлмөр эрхэлдэг хүн нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд нэгэн зэрэг хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд оршин сууж байгаа талынхаа хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

(7) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын төрийн албан хаагч нь хөдөлмөр эрхэлж байгаа тухайн байгууллагын талын хууль тогтоомжийг мөрдөнө.

8 дугаар зүйл

Түр хугацаагаар томилон ажиллуулах

(1) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж байгаа хүнийг ажил олгогч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт тодорхой ажил гүйцэтгүүлэхээр томилж, тухайн ажлыг гүйцэтгэж байгаа бол 24 сар хүртэл хугацаанд Хэлэлцэн тохиролцогч эхний талын хууль тогтоомжийн үйлчлэлд хамрагдана.

(2) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрт хувиараа хөдөлмөр эрхлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт түр хугацаагаар хөдөлмөр эрхэлвэл, тухайн хүн 24 хүртэл сарын хугацаанд Хэлэлцэн тохиролцогч анхны талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

(3) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий этгээд эсхүл эрх бүхий байгууллагын урьдчилан өгсөн зөвшөөрлийн дагуу нийтдээ 60 хүртэл сарын хугацаагаар сунгаж болно.

9 дүгээр зүйл

Олон улсын тээврийн байгууллагын ажилтан

(1) Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй олон улсын зорчигч болон бараа тээврийн үйлчилгээг газраар, төмөр замаар, агаараар эсхүл далайгаар эрхэлдэг хөлсний ажилтан болон бие даасан ажилтан тухайн бүртгэлтэй байгууллагын байрлаж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

(2) Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дэх салбар нэгж, байнгын төлөөлөгчийн газарт хөдөлмөр эрхэлж байгаа хүнд тухайн салбар нэгж, төлөөллийн газар байрлаж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомж үйлчилнэ.

10 дугаар зүйл
Хөлөг онгоцны багийн гишүүн, ажилтан

- (1) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын далбааг мандуулсан хөлөг онгоцон дээр хөдөлмөр эрхэлж байгаа хүн далбааг нь мандуулсан Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- (2) Хөлөг онгоцны багийн гишүүн биш боловч Хэлэлцэн тохиролцогч талын боомт буюу нутаг дэвсгэрийн усан дээр Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын далбаа бүхий хөлөг онгоцонд ачаа тээвэр хийх, буулгах, засварлах ажил эрхэлдэг, эсхүл удирдан зохион байгуулдаг хүн тухайн боомт, нутаг дэвсгэрийн ус харъяалах Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- (3) Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутагт дэвсгэрт оршин суугаа хүн нь тухайн талын нутаг дэвсгэрт байршилтай байгууллага эсхүл оршин суудаг этгээдээс цалинжиж Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын далбааг мандуулсан хөлөг онгоц дээр ажил, хөдөлмөр эрхэлсэн бол оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

11 дүгээр зүйл
Дипломат төлөөлөгчийн болон консулын ажилтан

- (1) Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд томилогдсон Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын Дипломат болон Консулын төлөөлөгчийн газрын ажилтан болон тэдгээрийн хувийн үйлчилгээний ажилтан нь илгээгч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- (2) Дипломат төлөөлөгчийн болон Консулын газарт тухайн орон нутагт оршин сууж байгаа хүн хөдөлмөр эрхэлж байгаа бол тухайн оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно. Хэрэв тухайн хөдөлмөр эрхэлж байгаа хүн нь ажил олгогч Хэлэлцэн тохиролцогч талын иргэн бол хөдөлмөр эрхэлж эхэлсэн өдрөөс хойш гурван сарын дотор ажил олгогч талын хууль тогтоомжийг мөрдөх эсэхээ сонгож болно.

12 дугаар зүйл
Онцгой тохиолдол

Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд нь хувь хүн болон бүлэг хүмүүст холбогдох хууль тогтоомжийн талаар заасан энэ хэлэлцээрийн 7-оос 11 дүгээр зүйлд үл хамаарах зүйлийн талаар харилцан тохиролцож болно.

III БҮЛЭГ ТУСГАЙ ЗҮЙЛ

1 ДҮГЭЭР ХЭСЭГ ТЭТГЭМЖ

13 дугаар зүйл Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн дагуу олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ, үргэлжлэх хугацаа, төлбөрийн арга хэрэгслийг тэтгэмж олгож байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу тодорхойлно.

2 ДУГААР ХЭСЭГ ӨНДӨР НАСНЫ, ТАХИР ДУТУУГИЙН БОЛОН ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

14 дүгээр зүйл Шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох

- (1) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамаарч тэтгэвэр авах эрх үүсдэг бол тухайн талын эрх бүхий байгууллага шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацааг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацаатай нэгтгэн тооцно. Ингэхдээ даатгалын шимтгэл төлсөн давхардсан хугацааг оруулан тооцохгүй.
- (2) Даатгуулагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөлийг хангахгүй байгаа тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагууд нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулсан гуравдагч талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцно.
- (3) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах эрхийг нь тусгай нөхцөл, болзлын дагуу шимтгэл төлсөн тодорхой хугацааг үндэслэн тогтоодог бөгөөд тухайн нөхцөл, болзол нь хоёр талд адил мөрдөгддөг бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд тусгай нөхцөл, болзлын дагуу шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцно. Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нөгөө тал ийм тусгай нөхцөл, болзлыг мөрдлөг болгодоггүй бол энэ хугацааг ердийн тэтгэвэр тогтоох хугацаанд нэгтгэн тооцно.

- (4) Туркийн талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн нэг сарыг 30 хоног, нэг жилийг 360 хоногтой адилтган тооцно. Монголын талын хувьд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг монголын талын холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцно.

15 дугаар зүйл

Нэг жилээс доош хугацааны даатгал

- (1) Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу зөвхөн шимтгэл төлсөн тухайн хугацаанд ноогдох тэтгэвэр авах эрх үүсэхээс бусад тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь 12 сараас бага бол тэтгэвэр олгохгүй.
- (2) Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага тэтгэвэр авах эрх үүссэн даатгуулагчийн тэтгэврийн хэмжээг тогтоохдоо энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг өөрийн орны хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн мэтээр адилтган тооцно.

16 дугаар зүйл

Тэтгэврийн хэмжээг тогтоох

- (1) Энэхүү хэлэлцээрийн 14 дүгээр зүйлд заасныг үл харгалзан Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах эрх үүсэхээр бол тухайн Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага зөвхөн өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацааг үндэслэн тэтгэврийн хэмжээг тогтооно.
- (2) Хэрэв Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн хүрээнд энэхүү хэлэлцээрийн 14 дүгээр зүйлд заасны дагуу даатгуулагчийн тэтгэвэр авах эрх үүсч байгаа бол тухайн Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага тэтгэврийг дараахь байдлаар тогтооно:
- а) эрх бүхий байгууллага нь даатгуулагчийн хоёр талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн нийт хугацааг өөрийн орны хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн мэтээр тооцож, тэтгэврийн онолын хэмжээг тогтооно.
 - б) эрх бүхий байгууллага нь тэтгэврийн онолын нийт хэмжээнд үндэслэн өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу даатгуулсан хугацаанд ноогдох тэтгэврийн бодит хэмжээг тогтооно.
- (3) Эрх бүхий байгууллага нь өөрийн мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу төлсөн шимтгэл эсхүл орлогыг үндэслэн тэтгэврийн хэмжээг тогтооно.

- (4) Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн хэмжээ нь гэр бүлийн гишүүдийн тооноос хамаардаг бол эрх бүхий байгууллага нь тэтгэврийн хэмжээг тооцохдоо Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суугаа гэр бүлийн гишүүдийн тоог мөн тооцно.

3 ДУГААР ХЭСЭГ ОРШУУЛГЫН ТЭТГЭМЖ

17 дугаар зүйл

Даатгал төлсөн хугацааг нэгтгэх болон оршуулгын тэтгэмж олгох

- (1) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу оршуулгын тэтгэмж олгох эрх нь шимтгэл төлсөн хугацаанаас хамаарч үүсдэг бол тухайн талын эрх бүхий байгууллага нь шаардлагатай гэж үзвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцно. Ингэхдээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн давхардсан хугацааг тооцохгүй.
- (2) Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу даатгуулсан этгээд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт нас барсан тохиолдолд даатгуулсан талын нутаг дэвсгэрт нас барсанаар тооцож оршуулгын тэтгэмж олгоно.
- (3) Хэрэв Хэлэлцэн тохиролцогч хоёр талын аль алиных нь хууль тогтоомжоор оршуулгын тэтгэмж авах эрх үүссэн бол зөвхөн нас барахын өмнө оршин сууж байсан талын хууль тогтоомжийн дагуу тэтгэмжийг олгоно.
- (4) Даатгуулагч эсхүл тэтгэвэр авагч нь гуравдагч улсын нутаг дэвсгэрт нас барсан бол хамгийн сүүлд шимтгэл төлж, даатгуулсан Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу тэтгэмжийг олгоно.

4 ДҮГЭЭР ХЭСЭГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН

18 дугаар зүйл

Мэргэжлээс шалтгаалсан өвчин

- (1) Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчин нь тухайн талын нутаг дэвсгэрт анх илэрч, оношлогдсон байх нөхцөлтэйгөөр тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсдэг бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт анх илэрч,

оношлогдсон мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг өөрийн нутаг дэвсгэрт илэрч, оношлогдсон мэтээр үзнэ.

- (2) Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийг тогтоохдоо уг өвчнийг үүсгэж болох ажил, хөдөлмөрийг эрхэлсэн хугацааг тусгайлан харгалздаг бол тухайн талын эрх бүхий байгууллага нь шаардлагатай гэж үзвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу ижил төстэй ажил, хөдөлмөр эрхэлсэн хугацааг тооцно.

19 дүгээр зүйл

Мөнгөн тэтгэвэр, тэтгэмж

- (1) Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжид мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж олгохоор заасан бол, тухайн өвчнийг үүсгэх ажил хөдөлмөрийг хамгийн сүүлд эрхэлсэн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж олгоно.

- (2) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж авдаг даатгуулагч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суух хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь нэмэгдвэл асуудлыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

(а) даатгуулагч нь Хэлэлцэн тохиролцогч хоёр дахь талын хууль тогтоомжийн дагуу тухайн мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэх эсхүл хүндрэхэд нөлөөлөхүйц ажил, хөдөлмөр эрхлээгүй бол Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллага өөрийн хууль тогтоомжийн дагуу тухайн хүндрэлийг харгалзан үзэж тэтгэвэр, тэтгэмжийг олгоно.

(b) даатгуулагч нь Хэлэлцэн тохиролцогч хоёр дахь талын хууль тогтоомжийн дагуу ажил, хөдөлмөр эрхэлж байгаад мэргэжлээс шалтгаалсан өвчин нь хүндэрсэн бол үүнийг үл харгалзан Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллага өөрийн хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно. Харин даатгуулагчийн Хэлэлцэн тохиролцогч эхний талаас авч байгаа тэтгэвэр, тэтгэмж болон мэргэжлээс шалтгаалсан өвчин хүндэрсний дараа авбал зохих тэтгэврийн хэмжээний зөрүүг Хэлэлцэн тохиролцогч хоёр дахь талын эрх бүхий байгууллага өөрийн хууль тогтоомжийнхоо дагуу тооцож олгоно.

IV БҮЛЭГ БУСАД ЗААЛТ

20 дугаар зүйл

Удирдлага болон хамтын ажиллагааны аргачлал

- (1) Хэлэлцэн тохиролцогч талуудын Эрх бүхий этгээд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангана.
- (2) Хэлэлцэн тохиролцогч талуудын Эрх бүхий этгээд хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлаарх шаардлагатай мэдээлэл болон тус хэлэлцээрийн хэрэгжилтэд нөлөөлөхүйц өөрчлөлт дотоодын хууль тогтоомжид орсон тохиолдолд уг өөрчлөлтийн талаарх мэдээллийг харилцан шуурхай солилцоно.
- (3) Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон харилцагч байгууллагуудыг тодорхойлно.
- (4) Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллагууд энэхүү хэлэлцээр болон хэлэлцээрийг хэрэгжүүлэх Удирдлагын тохиролцооны талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх ажлыг хариуцан зохион байгуулна.
- (5) Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон байгууллагууд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлууд нь өөрийн улсын хууль тогтоомжид нөлөөлж байгаа мэтээр харилцан туслалцаа үзүүлнэ. Туслалцааг харилцан үнэ төлбөргүй үзүүлнэ.
- (6) Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн нь эмнэлэгийн үзлэгт хамрагдах тохиолдолд хүсэлт гаргасан талын эрх бүхий байгууллагын зардлаар оршин суугаа талын эрх бүхий байгууллага үзлэгийг зохион байгуулна. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хоёулангийнх нь хууль тогтоомжийн дагуу хийгдэж байгаа эмнэлэгийн үзлэгийн төлбөрийг тухайн оршин суугаа талын эрх бүхий байгууллага хариуцна.

21 дүгээр зүйл

Хувийн мэдээлэл хамгаалах

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд дамжуулсан хувь хүнтэй холбоотой мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд тухайн мэдээллийг зөвхөн энэхүү хэлэлцээр болон хамаарах хууль тогтоомжийн хүрээнд ашиглана.

22 дугаар зүйл
Дипломат төлөөлөгчийн газрын бүрэн эрх

Хэлэлцэн тохиролцогч талын Дипломат болон Консулын төлөөлөгчийн газар нь өөрийн орны иргэдийн энэхүү хэлэлцээртэй холбогдон үүсэх эрх ашгийг хамгаалах зорилгоор Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллага, болон харилцагч байгууллагад шууд хандан мэдээлэл авч болно.

23 дугаар зүйл
Албан ёсны хэл

- (1) Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий этгээд, байгууллага монгол, турк эсхүл англи хэлээр харилцана.
- (2) Талууд өргөдөл, албан ёсны баримт бичгийг монгол, турк, англи хэлээр боловсруулсан гэсэн үндэслэлээр татгалзаж, буцаах эрхгүй.

24 дүгээр зүйл
Баримт бичгийн баталгаажуулалт болон төлбөрөөс чөлөөлөх

- (1) Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжид баримт бичгийг төлбөр, хураамжаас хөнгөлж, чөлөөлдөг бол нөгөө талын хууль тогтоомжийн дагуу болон энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор хүргүүлсэн аливаа мэдэгдэл, бусад баримт бичгийг төлбөр, хураамжаас мөн адил хөнгөлж, чөлөөлнө.
- (2) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч хоёр талын албан ёсны байгууллагаас иргэнд олгосон тодорхойлолт, мэдэгдэл, баримт бичгийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө тал баталгаажуулахгүй.

25 дугаар зүйл
Бичгээр өргөдөл, хүсэлт гаргах

- (1) Даатгуулагч, тэтгэвэр авагч нь энэхүү хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар өргөдөл, хүсэлтээ өөрийн оршин сууж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагад гаргана.
- (2) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомж эсхүл энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллага эсхүл харилцагч байгууллагад хүргүүлсэн баримт

бичгийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллага эсхүл харилцагч байгууллагад хүргүүлсэнтэй адилтгаж үзнэ.

- (3) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж авах хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу хүсэлт гаргасантай адилтгаж үзнэ.
- (4) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд хүргүүлсэн өргөдөл, мэдэгдэл эсхүл давж заалдах өргөдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллага эсхүл харилцагч байгууллагад мөн адил хуулийн хугацаанд хүргүүлсэнд тооцно.
- (5) Энэ зүйлийн 1-ээс 4 дүгээр хэсэгт дурдсан байгууллагууд нь хүлээж авсан өргөдөл, мэдэгдэл, давж заалдах өргөдлөө Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад шууд эсхүл харилцагч байгууллагаараа дамжуулан цаг алдалгүй хүргүүлнэ.

26 дугаар зүйл **Хохирлын нөхөн төлбөр**

- (1) Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт болсон хохирлын улмаас Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж авч, уг хохирлын төлбөрийг тухайн талын хууль тогтоомжийн дагуу гуравдагч этгээдээс гаргуулах бол нөхөн төлбөр гаргуулах эрхийг Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллагад нь шилжүүлнэ.
- (2) Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий байгууллага нэг үйл явдлын улмаас ижил төрлийн тэтгэвэр, тэтгэмж олгосноос хохирол учирсан бол гуравдагч этгээд нөхөн төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч аль нэг талд нь төлж болно. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий байгууллага нь хүлээн авсан нөхөн төлбөрийн дүнг тус тусын олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээгээр хувааж авна.

27 дугаар зүйл **Үндэслэлгүй олгосон төлбөрийг буцаан төлүүлэх**

Энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий байгууллага нь даатгуулагчид үндэслэлгүй тэтгэвэр, тэтгэмж олгосон тохиолдолд холбогдох тэтгэвэр, тэтгэмжийг олгох үүрэг бүхий Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хүсэлт гаргаж

даатгуулагчийн авч байгаа тэтгэвэр, тэтгэмжээс илүү төлсөн төлбөрийг суутган авч болно. Хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий байгууллага нь даатгуулагчид олгох тэтгэвэр тэтгэмжээс зохих дүнгээр суутгасан төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

Хэрэв төлбөрийг дээрх байдлаар төлүүлэх боломжгүй тохиолдолд дараахь журмаар төлүүлнэ:

(а) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий байгууллага нь даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмжийг үндэслэлгүйгээр илүү олгосон тохиолдолд тухайн эрх бүхий байгууллага нь холбогдох хуулийн хүрээнд тэтгэвэр, тэтгэмжийг төлөх үүрэг бүхий Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хандаж, даатгуулагчид олгох тэтгэвэр, тэтгэмжээс нь илүү олгосон хэмжээгээр суутгал хийлгэх хүсэлт гаргаж болно.

Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага нь үндэслэлгүй илүү олгосон төлбөрийг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу илүү олгосон мэтээр тооцож, суутган суутгасан төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

(b) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий байгууллага хууль тогтоомжийнхоо дагуу даатгуулагчид урьдчилан төлбөр олгосон бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хүсэлт гаргаж урьдчилан олгосон төлбөрийг тухайн сарын тэтгэмжээс суутгуулж болно. Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага төлбөрийг суутган, хүсэлт гаргасан Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

(c) хэрэв Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага нь даатгуулагчид тухайн үед тэтгэвэр, тэтгэмжийг нь олгосон тохиолдолд энэхүү зүйлийн (a) болон (b) заалтын дагуу гаргасан хүсэлтийг биелүүлэхгүй.

28 дугаар зүйл **Шимтгэл цуглуулах**

(1) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий байгууллагад төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага нь өөрийн шимтгэлийн өрийг төлүүлдэгтэй ижил журам, дарааллын дагуу барагдуулах арга хэмжээ авна.

- (2) Энэхүү зүйлийг хэрэгжүүлэх журмыг Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүдийн хооронд байгуулах Удирдлагын тохиролцоогоор зохицуулна.

29 дүгээр зүйл
Төлбөр хийх мөнгөн тэмдэгт

- (1) Энэхүү хэлэлцээрт заасны дагуу олгох аливаа тэтгэвэр, тэтгэмжийг төлбөр хийж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын мөнгөн тэмдэгтээр олгоно. Энэ нь илүү олгосон төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд шилжүүлэхэд мөн адил хамаарна.
- (2) Энэ хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас гаргасан эрүүл мэндийн үзлэгийн зардлыг төлөх үүрэгтэй бол, энэ төлбөрийг хоёр дахь талын мөнгөн тэмдэгтээр нэхэмжилж болно. Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллага нь төлбөрийг өөрийн орны мөнгөн тэмдэгтээр хийнэ.

30 дугаар зүйл
Тоон мэдээлэл солилцох

Хэлэлцэн тохиролцогч талуудын харилцагч байгууллагууд хэлэлцээрийн дагуу даатгуулагчид олгосон төлбөрийн тухай жилийн тоон мэдээллээ дараа жилийн 7 дугаар сарын 31-ний дотор солилцоно. Энэхүү тоон мэдээлэл нь даатгуулсан хүний тоо, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, төрлийг багтаасан байна. Энэхүү тоон мэдээллийг маягтаар солилцоно.

31 дүгээр зүйл
Маргаан шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд эсхүл эрх бүхий байгууллагууд яриа хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.

V БҮЛЭГ
ШИЛЖИЛТИЙН БОЛОН ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

32 дугаар зүйл
Шилжилтийн заалт

- (1) Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацааны тэтгэвэр, тэтгэмжийг уг хэлэлцээрээр нөхөн олгохгүй.

- (2) Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг хэлэлцээрээс үүдэн гарах эрхийг тодорхойлохдоо тооцно.
- (3) Өмнө нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж аваагүй бөгөөд тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг нь түдгэлзүүлсэн хүн хүсэлт гаргавал энэхүү хэлэлцээрийн дагуу тэтгэвэр, тэтгэмж авч болно.
- (4) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүсэлт ирүүлсэн бол тухайн даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг хугацаа хоцорсон гэж үзэлгүйгээр хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн эрх нь үүссэнд тооцно. Хэрэв хоёр жилийн дараа хүсэлт гаргасан бол хүсэлт гаргасан өдрөөс эхлэн тооцно.

33 дугаар зүйл

Соёрхон батлах, хүчин төгөлдөр болох

Энэхүү хэлэлцээрийг Хэлэлцэн тохиролцогч талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу соёрхон батлах бөгөөд Хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа бичгээр, дипломат шугамаар ирүүлсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 3 дахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

34 дүгээр зүйл

Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах

Талууд харилцан бичгээр зөвшилцсөний үндсэн дээр энэхүү хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн 33 дугаар зүйлд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

35 дугаар зүйл

Хэлэлцээрийн хугацаа болон хэлэлцээрийг цуцлах

Энэхүү хэлэлцээр нь тодорхойгүй хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах тухайгаа 6 сарын өмнө дипломат шугамаар урьдчилан мэдэгдэн цуцалж болно.

36 дугаар зүйл

Тэтгэврийн эрхийг хадгалах

- (1) Энэхүү хэлэлцээрийн дагуу тогтоосон тэтгэвэр тэтгэмж авах эрх нь хэлэлцээрийг цуцлах тохиолдолд хэвээр хадгалагдана.

(2) Энэхүү хэлэлцээрийг цуцлах үед шийдвэрлэх шатанд байгаа тэтгэвэр, тэтгэмжийн эрхтэй холбогдох бүх хүсэлтийг энэхүү хэлэлцээрийн зохицуулалтын дагуу бүрэн шийдвэрлэнэ.

ҮҮНИЙГ ГЭРЧИЛЖ, зохих эрх олгогдсон төлөөлөгчид энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Анкара хотноо монгол, турк, англи хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

